

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

Нээлттэй Нийгэм Форумаас «Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль»-ийн төслийн хэлэлцүүлгийг төрийн бус байгууллага, эрдэмтэн, судлаачдын оролцоотойгоор 2014 оны 11 дүгээр сард зохион байгууллаа. Хуулийн төсөлд өгсөн санал, шүүмжийг боловсруулахдаа НҮБ-ын хүний эрхийн гэрээ конвенц, жишиг стандарт, хүний эрхийн механизмуудаас өгсөн зөвлөмж, дүгнэлтийг анхааран судалсан. Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай загвар хууль, бусад улс орны хууль тогтоомжийг харьцуулан үзлээ. Хэлэлцүүлгийн явцад гарсан санал, шүүмжийг нэгтгэн танилцуулж байна.

Хуулийн төслийн хэлэлцүүлэгт хуулийн их дээд сургууль, судлаачдаас Н.Жинжиймаа, Д.Насанбат (МУИС-ийн Хууль зүйн ухааны сургууль), Н.Туяа (МУИС-ийн Хууль зүйн сургууль), Т.Оюунчимэг (судлаач, доктор), төрийн бус байгууллагаас Г.Баярмаа (Монголын Чөлөөт Нийгмийн Ажилтны төв), Г.Ганбаясгах (Хүйсийн тэгш эрхийн төв), А.Гэрэл-Ундрам, Г.Даваабал (Монголын байгаль орчны төлөөх хуульчдын холбоо), К.Жанибек (Хөгжлийн хэлхээ), Д.Мөнхнасан (Залуус эрүүл мэнд төв), Н.Наранцэцэг (Монголын байгаль эхийн аврал сан), Б.Нямбаяр (Хар тамхи мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг), А.Оюунчимэг (Булаг шанд гол мөрний эхийг хамгаалах сан), Д.Сафрантуяа (Татварт иргэний хяналт), Ч.Сэмжидмаа (Сэтгэл зүйн мэдрэмж), Г.Төмөрмөнх (Ногоон соёл иргэншил хөгжил сан), Д.Цэнд-Аюуш (Хууль, хүний эрх төв), С.Цэндбаатар (Үндсэн уртлаг), Б.Энхсайхан, Д.Энхцэцэг (Хотын захын гэр хороолол хөгжил сан) болон Б.Хишигсайхан (Нээлттэй Нийгэм Форум) нар оролцлоо.

Нэг. ЕРӨНХИЙ САНАЛ, ДҮГНЭЛТ

1. Хууль бүтээх үйл ажиллагаа нь хуулийн хэсэг, бүлэг, зүйл заалтууд хоорондоо уялдаа холбоо бүхий нэг үзэл санаа агуулгыг бүрэн гүйцэд илэрхийлсэн байх, тодорхой ойлгомжтой, цэгцтэй дэс дараалал бүхий, хэмнэлттэй байх наад захын шаардлагыг зөрчжээ. Мөн хуулийн төслийн зарим бүлэгт огт хамааралгүй заалтуудыг оруулсан, адил утга бүхий бүлгүүдийг нэгтгээгүй зэрэг хуулийн системчлэл алдагдсан дутагдал нэлээд байна. Хуулийн төсөлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх онцгой журам, тусгай журмын зохицуулалтыг нэг бүлэгт хамааруулаагүй нь хуулийн бүтэц алдагдсан болохыг харуулж байна. Тухайлбал, Хуулийн төслийн 3 дугаар бүлэгт «Шүүхийн зардал»-ын бүрдэл, гэрч, шинжээч, хэлмэрч, орчуулагчид зардал төлөх, шүүхийн зардлыг хэрхэн гаргуулах тухай дурдсан боловч энэ бүлэгт огт хамааралгүй «шүүх хуралдааны тэмдэглэл», «шүүх хуралдааны тэмдэглэл танилцуулах», «баримт бичгийг хүргэх» гэсэн зүйл заалтыг оруулсан, мөн төслийн 29 дүгээр бүлэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тусгай журмыг зохицуулсан боловч төслийн 11 дүгээр бүлэгт онцгой журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэж оруулжээ.

Санал: Хуулийн төслийн уялдаа холбоог илэрхийлсэн бүтцийг шинээр авч үзэх.

- Хуулийн төслийн танилцуулгад «зарчмууд тунхаглалын шинжтэй» байсан учир тухайн шатны үйл ажиллагаа, оролцогчийн эрхтэй холбон тусгасан гэжээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдлөг болгох зарчмыг зохицуулалтын түвшинд суулгаж өгсөн нь сайшаалтай ч тухайн ажиллагааны хууль ёсны эсэхийг тогтоох шалгуур, оролцогчдын эрхийн баталгаа болдог тул тусгайлан оруулах шаардлагатай юм. Тусгайлан зарчмыг зааж өгөөгүйгээс оролцогчдод ялгавартай хандах, зарим оролцогчдын эрхийг хохироох, зарим оролцогчдод ямар ч зарчим үйлчлэхгүй мэт болсон нь хуулийн төслөөс харагдаж байна. Тухайлбал, төслийн 7-р бүлэгт суурь зарчмыг зөвхөн яллагдагчийн эрхтэй холбон дурдсан нь бусад оролцогчдын эрхийг хангах нийтлэг зарчим болж чадахгүй байна.

Санал: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дагаж мөрдөх ерөнхий зарчмуудыг хуулийн төсөлд тусгаж оруулах.

- Аливаа хуулийн төсөлд хэрэглэгдэж буй нэр томъёо нь олон утгатай, өргөн утгатай бөгөөд нарийвчлан тодорхойлох шаардлагатай, эсхүл шинээр бий болсон ойлголт буюу нийтэд ойлгомжгүй бол нэр томъёоны тайлбар хийх ёстой. Энэ нь хуулийн төслийн нийтлэг шаардлагад хамаардаг. Учир нь хууль хэрэглэх үед нэр томъёоны нэгдсэн ойлголтгүй байх нь хуулийг нэг мөр ойлгож хэрэглэхэд хүндрэл учруулж, улмаар өөрсдийн үзэмжээр тайлбарлаж хэрэглэх, хууль зөрчих нөхцлийг бүрдүүлдэг.

Санал: Хуулийн төсөлд нэр томъёоны тодорхойлолтыг нэмж тусгах.

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол оролцогч болох хохирогчийн эрх зүйн байдлыг дордуулж Үндсэн хуульд заасан өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах, шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрхийг үндэслэлгүйгээр хязгаарлажээ. Хуулийн төсөлд прокурор хохирогчийн эрхийг хамгаалах тухай ерөнхий заалт орсон боловч прокурорын бүрэн эрхэд энэ талаар дурдаагүй тул энэ хэм хэмжээг хэрэгжих нөхцлийг хаасан байна.

Санал: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогчийн өмгөөлүүлэх, давж заалдах гомдол гаргах, татгалзан гаргах эрхээр хангах заалтуудыг шинээр нэмж оруулах.

- Тус хуулийн төсөлд иргэний өмгөөлүүлэх эрхэд шууд халдсан зохицуулалтыг нийтлэг байдлаар тусгасан нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээний зарчим, хэм хэмжээнд нийцэхгүй байна. Мөн түүнчлэн төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй улсын өмгөөлөгчийг «жижүүрийн өмгөөлөгч» мэт үзэж, нөхөөс байдлаар ажиллагаанд татаж оролцуулахаар тусгасныг зөвтгөх аргагүй байна. Энэ тохиолдолд улсын өмгөөлөгчийн төлбөрийг хэрхэх, тус өмгөөлөгч нь үндсэн чиг үүргээ бүрэн дүүрэн, чанартай гүйцэтгэхэд энэ зохицуулалт хэрхэн нөлөө үзүүлэх зэргийг олон талаас нь судалж үзсэний үндсэн дээр зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзэж байна.
- Тус хуулийн төсөлд нэг нэр томъёогоор өөр өөр зүйлийг нэрлэсэн нь учир дутагдалтай байна. Тухайлбал, «гэрч» гэх үгээр хүн болон эд зүйлийг төлөөлүүлэхээр хуулийн төсөлд тусгажээ.

Хоёр. ТУСГАЙ САНАЛ, ДҮГНЭЛТ

	Зүйл, хэсэг	Санал зөвлөмж	Үндэслэл
1.	1.8.1.2 1.8.1.4	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа /ЭХХША/-нд «сэжигтэн» оролцох тохиолдолд эрх, үүргийг тодорхойлсон заалт нэмэх	Хуулийн үзэл баримтлалаар «сэжигтэн» ЭХХША-д оролцохгүй гэжээ.
2.	1.8.1.2	«Сэжигтэн, яллагдагч хуульд заасан ял эдлэх насанд хүрээгүй» гэж найруулах	
3.	2.1.6	«Хяналтын шатны шүүхээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхдээ хуулийг зөв хэрэглэсэн эсэхэд холбогдох маргааныг хянан хэлэлцэнэ» гэж найруулах	
4.	2.2.1	«өсвөр насны хүн» гэдгийг тодорхой болгох	
5.	2.5.1.3	ЭХХШ ажиллагаанд «зохиогч», «гуравдагч этгээд», «хөндлөнгийн гэрчээр» оролцсон бол шүүгч оролцохгүй байхаар оруулсан боловч эдгээр оролцогчдын эрх үүргийн тодорхой заах	Иргэний хэрэг хянан шийдвэрлэх хуулийн нэр томъёо оруулсан нь зохимжтой эсэх
6.	2.5.5	«хуульд заасан хариуцлага» гэдэгт холбогдох хуулийг ишлэх	
7.	2.7 5.2	Шүүгч, прокурорыг татгалзан гаргах эрхийг «хохирогч», «хохирогчийн өмгөөлөгч» нарт олгохоор нэмж оруулах	Тэгш байдал алдагдсан
8.	2.9	Иргэдийн төлөөлөгчийг 2.8-д заасан журмаар шийдвэрлэнэ гэсэн ч, энэ журмаар хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй байна.	
9.	2.10.2	Шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзсан шийдвэрт мөн адил 2.8 хэрхэн үйлчлэх нь тодорхойгүй байна.	
10.	3.1	Шүүхийн зардалд «хөндлөнгийн гэрч», «мэргэжилтэн», «төлбөрийн чадваргүй хохирогчийн өмгөөлөгч»-д төлөх зардлыг нэмж оруулах	Үндэслэлгүйгээр хассан
11.	3.3.2	«хөрөнгийн байдлыг харгалзан» гэдэг нь ялгаварласан заалт байна. Илүү хөрөнгөтэй байсны төлөө илүү зардал төлнө гэдэг нь шударга ёс биш.	
12.	3.3.5	«шүүхийн тамгын газар тогтооно» гэдэг нь ойлгомжгүй байна. «Засгийн газраас тогтоосон томилолтын зардал, цалин хөлсний болон гэрээнд заасан хэмжээгээр тогтооно» гэж өөрчлөх	Хуулийг нэг мөр хэрэглэх үүднээс нийтлэг стандарт тогтоох нь зүйтэй.
13.	3.4.1	«баталгаажуулна» гэсэн нь оновчтой томъёолол биш.	
14.	3.4.2	«эхийн» нэр гэж нэмж тусгах	
15.	3.6.2	«энэ тухай баталгаажуулж» гэснийг илүү тодорхой томъёолох	
16.	4.2	«дуудах» гэснийг «дуудан» гэж засах	
17.	4.2.2	«өмгөөлөгчөөр» гэснийг хасах	
18.	4.2.4	«Энэ хуулийн 13.1.2, 13.1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан» гэж өөрчлөх	
19.	4.5	Гэрч, шинжээч гэрч, хохирогчийг шүүхэд дуудан 4.1.1-д зааснаар амаар, харилцаа холбооны хэрэгслээр дуудан ирүүлэх заалт нэмэх	Тэгш байдал алдагдсан

20.	5.1	Төслийн 5.1 дүгээр зүйлийн гарчгийг «Прокурор түүний бүрэн эрх» гэж өөрчлөх, Прокурорын бүрэн эрхэд «хохилогчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг тууштай хамгаалах» тухай нэмж тусгах	Тэгш байдлыг хангах
21.	5.1.1	«мөрдөн байцаах ажиллагаа» гэснийг «мөрдөн шалгах ажиллагаа» гэж өөрчлөх	Нэр томъёог жигдлэх
22.	5.1.2	«дурсан» гэснийг «дурдсан» гэж засах	
23.	5.2.2	Прокурорыг татгалзан гаргах хүсэлт гаргах эрхийг «хохилогч, түүний өмгөөлөгчид олгох» заалт нэмэх	Хохилогчийн тэнцүү байдлыг хангах
24.	6.1.2.3	Өмгөөлөгч «нууц аргаар явуулсан мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлтэй танилцах эрхгүй» байхаар зохицуулсныг өөрчлөх	Тэгш байдал алдагдах
25.	6.1.2.7	«шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг» татгалзан гаргах тухай хүсэлт гаргах эрхийг нэмж тусгах	Прокурорын нэг адил эдлэх ёстой эрх
26.	6.2.7	«хэвийн үйл ажиллагааг алдагдуулахаар бол шүүх улсын өмгөөлөгчийг оролцуулна» гэсэн хэсгийг хасах	ЭХХША-ны хэвийн байдлыг өмгөөлүүлэх эрхээс дээгүүр тавьсан
27.	6.3.1 .1	«өмгөөлүүлэх» гэснийг хасах	Өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй гэдэг нь утгагүй тул
28.	6.3.2	«улсын өмгөөлөгч» оролцуулна гэснийг эргэж нягтлах	
29.	7.1.2	«Бэлгийн чиг хандлага» гэснийг «Бэлгийн чиг баримжаа» болгох «Хүйсийн баримжаа» гэснийг «хүйсийн баримжаа илэрхийлэл» гэж өөрчлөх, «эрүүл мэндийн байдал» гэж нэмж тусгах	Олон улсын нэр томъёонд нийцүүлэх
30.	7.2.2	«бэлгийн чиг хандлага,» гэснийг «бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл» гэж өөрчлөх	
31.	7.3.2	«даруй мэдэгдэж» гэснийг илүү тодорхой заах, тухайлбал, баривчлагдах үед нь, ирсэн даруйд нь г.м	
32.	7.3.3	Суллах үүргийг цагдан хорих байрны дарга хүлээсэн тул давхцаж байна.	
33.	7.4.5	«Гэрч», «баримт», «үйл явдал», «эрх зүйн дүгнэлт» ойлгомжгүй байна.	Нэр томъёог жигдлэх
34.	7.6.1	Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн зарчимд нийцүүлэн өөрчлөн найруулах	
35.	7.14.1.5	«тэдний хамаарал бүхий» гэж хэн болохыг тодорхой тусгах	
36.	8.1.5	«хохилогчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах бол шүүх хуралдаанд прокурор төрийн өмнөөс оролцоно» гэсэн нь «хохилогчийг өмгөөлүүлэх эрхээр» хангана гэсэн агуулгыг илэрхийлэхгүй байх тул «хохилогч өмгөөлөгч авах эрхтэй» гэж өөрчлөх	Хохилогчийн эрхийн ноцтой зөрчил
37.	8.1.6	«хохилогч» гэдэг үгийн дараа «нас барсан» гэсэн үг нэмэх	Зөвхөн хохилогч нас барсан тохиолдолд хэрэгжих хэм хэмжээ
38.	8.2.2	«эсэх талаар» гэснийг «эсэхээ» гэж өөрчлөх	

39.	8.4.1 8.4.3	«яллах санал» гэсний дараа, «шүүгдэгчийн өмгөөлөгчийн саналд» гэсэн үгийг нэмэх	Гэрчийг хамгаалах нэрийн дор хохирогчийн эрхийг хязгаарласан
40.	Ес дүгээр бүлэг 9.1- 9.5	«бусад оролцогч» гэсэн бүлэгт «Гэрч» гэсэн зүйл, хэсэг нэмэх	Төсөлд гэрч, гэрч хүүхэд, шинжээч гэрч, хамтран ажиллах гэрч, тохирсон гэрч, нууцлагдсан гэрч гэж нэрлээд 12-р бүлэг, 22-р бүлэгт эмх цэгцгүй тайлбарласныг нэгтгэх
41.	9.4.4	«дохионы хэлний хэлмэрч» гэж солих	
42.	9.5.3	«тусгай чиг үүрэгтэй байгууллага» гэсэн нь тодорхойгүй	
43.	10.1.2	«хувь хүн» гэснийг «хүн», «явуулж болно» гэснийг «явуулна» гэж солих	
44.	10.2.2	«хүмүүс» гэснийг «хүн» гэж солих	
45.	11.1	«хор уршгийг нөхөн төлсөн» гэж нэмэх	Гэм буруугаа хүлээснийг голчилж хохирогчийн эрхийг хязгаарласан.
46.	11.2.2	Төслийн 11.2.1, 11.2.2 дахь заалтууд утга ижил тул 2 дахь заалтыг хасч, 11.2.1 дэх хэсэгт «шүүх болон прокурорт бичгээр гаргах» гэж өөрчлөх	
47.	11.4.3	11.4.3 нь 11.4.4-тэй зөрчилдөж байна.	Хоорондоо зөрчилдөж байна.
48.	11.8.3	Дэг зөрчсөн оролцогчдод «гэрч»-ийг нэмж оруулах	Тэгш байдлыг хангах
49.	11.8.5	«гомдол гаргах хугацаа»- г тодорхой заах	
50.	12.1	Гэрчийн аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуультай нийцүүлэх	
51.	12.2.2.2	12 жилийг 8 жил болгон өөрчлөх	Гэмт хэргийн тухай хуульд нийцүүлэх
52.	12.2.2.3	«гэмт хэргийн зохион байгуулагч» гэх	Найруулгын алдаатай
53.	12.3.1	«Гаргаж өгөх гэрч» гэдэг нь хүн гэж харагдаж байна.	Үүнийг тодорхойлох
54.	12.3.3	«Даруй» гэдэгт тодорхой хугацаа тавих	Найруулгын алдаатай
55.	12.6.3	«Гэрч түүний хуулийн зөвлөх» гэдгээс «хуулийн зөвлөх» гэдгийг хасах	нэр томъёог өөрчлөх
56.	12.6.4	Шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэлүүдийг хэн хэрхэн тогтоох нь тусгагдаагүй	Хамтран ажиллах гэрчийн эрх зөрчигдөх
57.	12.6.5	Хамтран ажиллах гэрч «үүргээ биелүүлээгүй» гэдгийг хэрхэн тогтоох нь тодорхойгүй байгааг өөрчлөх	Давхар хариуцлага хүлээх
58.	13.1.1	«дор дурдсан» гэсний дараа «төрлийн» гэсэн үг нэмэх	Найруулгын алдаатай
59.	13.3	Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг үйлдсэн яллагдагчид гэрийн хорио таслан сэргийлэх арга хэмжээ авахыг хориглох тухай заалт нэмэх	Хохирогчийн эрхийг хамгаалах
60.	13.4.2	«эсхүл түүний өмнөөс бусад хүн, хуулийн этгээд гаргаж болно» гэдгийг хасах	Төслийн 13.5.12-т зааснаар барьцааг улсын орлого болгох учир бусдын өмчлөх эрх зөрчигдөх

61.	13.5.1	Энэ хуулийн 13.2 гэснийг13.4 болгож өөрчлөх	
62.	13.6	13.6-д 3 дахь хэсгийг шинээр нэмэх «хувийн баталгааг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг» зааж оруулах	Тэгш байдлыг хангах
63.	13.8.5	«улсын өмгөөлөгч оролцуулна» гэдгийг эргэж харах	
64.	13.9.1.1	«авах» гэснийг хасах	Сул үг
65.	13.10.1	«Нотлох гэрч, баримт» гэсэн холбоо үгийг төслийн маш олон зүйлүүдэд хэрэглэсэн	Нэр томъёоны тайлбар хийх
66.	14.1.1.11	«Бэлгийн маргаантай» асуудал гэдгийг тодорхойлох	Нэр томъёоны тайлбар хийх
67.	14.8	Гэрч гэдэг үгийг объектоор ойлгож хэрэглэсэн мэт.	Хоёрдмол утга гарч байна.
68.	15.1	Хэнийг баривчлах нь тодорхойгүй байгаа тул «яллагдагч» гэж тодорхой зааж өгөх	Эрхээ хамгаалах боломж алдагдах
69.	15.4.3	«ял сонсгох ажиллагааны хугацааг прокурор хойшлуулж болно» гэсний «хугацааг» тодорхойлж өгөх	Яллах талд давуу эрх олгосон
70.	15 дугаар бүлэг	Баривчлах ажиллагаатай холбоотой 15.1 - 15.3 дахь заалтууд нь «Хууль сахиулах үйл ажиллагааны тухай» хуулийн холбогдох заалтуудыг ишлэсэн байх тул нарийвчлан зохицуулсан хуулиар зохицуулах боломжтой.	Хуулийн үзэл баримтлалыг зөрчиж байна.
71.	15.7.5	«дор» гэсэн илүү үгийг хасах	
72.	15.7.5.2	«товч» гэснийг «тов» болгох	
73.	15.7.7	«сэргигтэнд» гэснийг «сэжигтэнд» гэх	
74.	15.9	«прокурор» гэснийг хасах	Талуудын тэгш байдлыг хангах үүднээс
75.	16.7	Яллах ажиллагааг түр зогсоох нь үндэслэлтэй эсэх талаар шүүгдэгч, хохирогч тэдгээрийн өмгөөлөгч гомдол гаргаж, дээд шатны прокурорт хандах эрхийг тодорхойлсон 16.7.8 дахь хэсгийг шинээр оруулах	Яллах талын эрх давамгайлсан
76.	16.8	«яллах ажиллагааны хугацаа, урагшлуулах, хойшлуулах» гэсэн нэр томъёо хэтэрхий ерөнхий байгааг өөрчилж цаг, хоног, өдрөөр тооцох	Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим алдагдах
77.	16.11	Прокурор яллах саналд нэмэлт, өөрчлөлт оруулах журмыг зааж өгөх	Төслийн 16.3-р зүйлийн 1-7 огт байхгүй.
78.	16.15	Яллах санал хүргүүлэх гэсэн заалттай нэгтгэх /16.17/	
79.	16.16	Дугаар алгассан.	
80.	17.1.2	Баривчлах арга хэмжээ авагдаагүй сэжигтний өмгөөлөх үйл ажиллагаа хэзээ авах нь тодорхойгүй байна.	Тэгш байдлыг хангах
81.	17.1.3	«Дор дурдсан үйл ажиллагаа» гэснийг «Дор дурдсан эрх хэмжээ» болгон өөрчлөх	
82.	18.2.1	Яллах саналд хариу өгөх гэснийг 14 хоног болгож өөрчлөх	Өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлэх боломж

83.	18.3.1	«Яллах дүгнэлт» гэснийг «Яллах санал» болгож өөрчлөх	Нэр томъёог жигдлэх
84.	18.10	Гэрч, баримтыг ил болгох гэдгийг: «Гэрч», «баримт» гэх нэршлийг илүү тодорхой болгох 18.10, 18.11, 18.12-р зүйлийг «Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль»-д нийцүүлэн өөрчлөх	
85.	18.10.2	Хохирогч түүний өмгөөлөгч хэрхэн танилцах ажиллагаа нэмж оруулах	
86.	18.16	Энэ зүйлийн гарчигт «шүүхэд» гэдэг үгийг хасах	
87.	19 дүгээр бүлэг	Шүүх хуралдааны ерөнхий нөхцөлд гэрч, шинжээч гэрч, хохирогч шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүйн холбогдлыг тусгах	
88.	19.2	Шүүх хуралдааны танхимын зохион байгуулалт гэсэн зүйлд 19.2.7 «шүүх хуралдааны явцад дуу, дүрс, бичлэгийг танилцуулах тоног төхөөрөмжийг байрлуулах» гэсэн шинэ заалт нэмэх	Мэтгэлцэх зарчим
89.	21 дүгээр бүлэг	Уг бүлэгт нотлох баримтыг тодорхойлсон боловч гэрч баримт гэсэн нэр томъёог давхар хэрэглэсэн байна.	Нэр томъёог жигдлэх
90.	22.4.5	Төслийн уг заалтыг хасах	Хуулийн төслийн 22.2.1.1 дэх хэсэгт заасантай зөрчилдөж байна.
91.	22.4.7	«Дүлий» гэснийг «Хэл яриа, сонголын бэрхшээлтэй» гэж өөрчлөх, тангараг өргөх ажиллагааг нарийвчлан зохицуулах	Гэрчлэх эрхийг хангах
92.	22.11	«Байлцах хүн» гэсэн нэр томъёог тодруулах	
93.	24.5.1.6	«Гэмт хэргийн тухай хуулийн зүйл, хэсэг» гэж нэмэх	
94.	24.9.3	«учирсан хохирлыг нөхөн гаргуулах тухай дурдаж болно» гэсэн хэсгийг хасч «дурдана» гэж оруулах	Тэгш байдлыг хангах
95.	24.10, 27.13.2, 28.7.3	30 хоногийг 10 хоног болгох	
96.	24.13	Бүхэлд нь хасах	
97.	26.7.1	«мэдэгдэж болно» гэснийг «мэдэгдэнэ» гэж өөрчлөх	Хохирогчийн давж заалдах эрхийг хязгаарласан
98.	27.2, 27.3	Хоёр өөр зүйлд ижил нэр өгсөн. Нэгтгэх	Хуулийг системчлэх
99.	27.5.4	Хугацааг оновчтой зааж өгөх	Хөдөө орон нутагт энэ хугацаанд хүргүүлэх боломжгүй гэж үзэж байна
100.	27.8.1	Төслийн 27.8.2 дахь хэсэгтэй бие биенээ үгүйсгэсэн	Зөрчилдөөнтэй хэм хэмжээ
101.	27.10.7	Төслийн уг зүйл заалтыг бүхэлд нь хасах	Шинэ нөхцөл байдалтай адилтгасан
102.	27.10.9	Хүндэтгэн үзэх шалтгааныг дурдах	Тэгш байдлыг хангах
103.	27.11.2	Нэгдсэн саналаар, олонхийн саналаар гэж тодорхой оруулж өгснийг дахин эргэн харах	Шүүхийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлөх боломжтой, шүүх хуралдааны зөвлөлдөх тасалгааны нууц алдагдаж байна

104.	27.11.6	«Хүндрүүлэн өөрчилж болно» гэснийг зарчимд нийцүүлэн өөрчлөх	
105.	27.14.1	Найруулгыг эргэж харах, бүлэг, зүйлийн нэрийг нягтлах, тухайлбал, 18.19 байхгүй.	
106.	27.14.2	«шүүх, прокурорын шийдвэрийг» гэснийг «шүүхийн» гэсэн үгээр солих	Шүүхийн шийдвэрт гомдол гаргах гэсэн атлаа прокурор шийдвэр гаргана гэдэг нь ойлгогдохгүй байна
107.	27.16.6	Баримт бичгийг хүлээн авсанаас хойш 2 хоногийн дотор шийдвэрлэнэ гэснийг шилжүүлэнэ болгох	Найруулгын алдаатай
108.	28.1	«Хохирогч» гэсэн үгийг нэмэх	Хохирогчийн давах эрхийг хангах
109.	29.6	Дугаарлалтын алдаатай байна.	
110.	28.7.1.3	Агуулга эргэн харах, Анхан шатны шүүх гэж нэмж оруулах	Шүүх эрх мэдэл
111.	29.1.1.2	«Хортойгоор» гэсэн үгийг хасах	
112.	32.4.1	«харъяалалын» гэснийг «харъяаллын» гэх	
113.	32.4.3	«Эрүүгийн хуулиар» гэснийг тодруулах	
114.	33 дугаар бүлэг	«Өсвөр насны хүн» гэсэн нэр томъёог өөрчлөх	Олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх
115.4	33.4.6	«гаргах» гэснийг «гаргаж» гэх	
116.3	33.5.3	«хэсэгт» гэж нэмэх	
117.	33.2.6, 33.5.4	«улсын өмгөөлөгч» гэдгийг эргэж харах	
118.	33.7	Яллагдагч хүүхдийг цагдан хорих гэжээ.	Нэр томъёог жигдлэх
119.	33.7.1	«багаар» гэдэг нь тодорхойгүй	
120.	33.8.4	«шүүхиын» гэснийг «шүүхийн» гэх	
121.	34-р бүлэг	«хууль сахиулагч» нэмэх	
122.	34.2.2.3	«татгалзасан» гэснийг «татгалзсан» гэх	
123.	34.6	«хариуцана» гэснийг «хариуцна» гэх	
124.	34.9.9	«чөлөөлөгдөнөд» гэснийг «чөлөөлөгдөнө» гэх	
125.	34.10.1	«авсанаас» гэснийг «авснаас» гэх	

Дугаарыг эрхэлсэн: Н.ТУЯА
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Практик сургалтын төвийн эрхлэгч

Дугаарт оролцсон: Т.ОЮУНЧИМЭГ
Судлаач, Доктор
Б.ХИШИГСАЙХАН
ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер
Д.ЦЭНД-АЮУШ
«Хууль хүний эрх» төвийн Тэргүүн

Хаяг: Жамъян гүний гудамж - 5/1
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар - 14240
Монгол Улс

Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn